

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/150/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: [Dornogovi@audit.gov.mn](mailto:Dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: .....

Аудитор:

О.Нарангарав

Утас: 70523020

Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Зардлын данстай холбоотой .....	12
3.1.1	Илрүүлэлт:.....	12
3.1.2	Эрсдэл: .....	12
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	13
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	13
3.2	Орлогын данстай холбоотой .....	13
3.2.1	Илрүүлэлт:.....	13
3.2.2	Эрсдэл: .....	13
3.2.3	Өгсөн зөвлөмж: .....	13
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21

## 1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайшанда сум,  
Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД  
СУМ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Д.ЗОРИГОО ТАНАА

2019.01.23 № 1-6/32

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

9020000

#### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦАРИУНАА



## **2 АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 ОРШИЛ**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Зоригоод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 18-наас 2019 оны 01 дүгээр сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав гүйцэтгэж, хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь “үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гаалийн ерөнхий газрын 2016-2020 оны стратеги зорилтоор Дорноговь аймгийн замын-үүд сум дахь гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх
- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль бус барааны эргэлттэй тэмцэх чадавхийг дээшлүүлэх

- Тарифын зохистой бодлого хэрэгжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрэн дүүрэн бүрдүүлэх
- Гаалийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, мэргэшсэн, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангах, хүний нөөцийг чадавхийг хөгжүүлэх
- Гаалийн байгууллагад өөрчлөлтийн менежмент, сайн засаглалыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх
- Хилийн хяналтыг зохицуулах менежментийг хэрэгжүүлэх, бараа тээврийн хэрэгслийн урсгалыг саадгүй болгох
- Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, бизнесийн таатай орчныг бий болгох, худалдааг хөнгөвчлөх
- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх
- Мэдээллийн технологийг хөгжүүлэх, цаасгүй бүрдүүлэлтэд шилжих боломжийг бүрдүүлэх

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд
- Сангийн сайдын төсвийн үйл ажиллагаатай холбоотой тушаалууд
- Гаалийн ерөнхий газрын холбогдох хууль тогтоомж

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн 1 хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгийн дүн нийт мөнгөн гүйлгээний тайлангийн зарлагын дүнгээс их байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны 12 сарын 31-рх тайлангийн нийт зардал 8716.4 сая төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 17.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшинд ойртуулсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад залруулах боломжтой гэж үзлээ. Энэ үр дүнг В30101 маягтаар баталгаажуулав. Харин аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар тус тус нэгтгэн баталгаажуулав.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа,  
зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	11.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	2	11.7	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал**

2018 онд орох түрээсийн орлогоос 120. мянган төгрөгийн дутууг авлагад бүртгээгүй, мөн нийт орсон орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх дүнгээс 180.0 мянган төгрөгийн дутуу төлөлтийг өр төлбөрөөр тайлагнаагүй байна.

Энэ нь Иж бүрэн байх, Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус зөрчсөн байна..

#### **Шийдвэрлэсэн:**

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

### **2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал**

Нийт бодогдсон цалин болон Нийгмийн даатгалын тайлангийн цалингийн дүн 2.3 сая төгрөгөөр зөрүүтэй, үүний улмаас 0.4 сая төгрөгийн илүү төлөлт үүссэнийг авлагаар тусгаагүй. Мөн нийгмийн даатгалын сангаас 1.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын урамшуулал олгогдож төлбөрийн дүнгээс хассаныг үр дүнгийн тайланд тайлагнаагүй байна.

Энэ нь Иж бүрэн байх, Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус зөрчсөн байна..

#### **Шийдвэрлэсэн:**

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,397.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,353.6 сая төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь бараа материалын зарим зардал зарцуулагдаагүй хэмнэлттэй үлдсэн нь шалтгаалжээ.

Түрээсийн орлогыг 8.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, цалин, НДШ-ийн зардал 33.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 9.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газар нь 2018 онд улсын төсвөөс 3,347.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 58.1 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 24.0 сая төгрөг, НДС-ийн тэтгэмжийн орлого 20.5 сая төгрөг буюу нийт 3,449.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 2,800.9 сая төгрөг нь нийт зардлын 81.2 хувь, бараа үйлчилгээний урсгал зардал 597.2 сая төгрөг нь нийт зардлын 17.3 хувь, Төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 51.5 сая төгрөг нь нийт зардлын 1.5 хувийг тус тус эзэлж байна. Тайлант оны эцэст зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 51.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дэх Гаалийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум дэх Гаалийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Үйл ажиллагааны зардлаас 4.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулан гүйлгээ хийсэн байна. Үүнд:

- Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлаас 800.0 мянган төгрөг, Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 211.9 мянган төгрөг нийт 1011.9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсан
- Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 1800.0 мянган төгрөг, Багаж, техник, хэрэгслийн зардлаас 1383.4 мянган төгрөг нийт 3183.4 мянган төгрөгөөр цэвэрлэгээний материал худалдан авсан

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 16.5.5, дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавартай”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн зардал буруу тайлагнагдах, төсөв буруу батлагдах эрсдэлтэй.

### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан тайлагнаж байх.

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

## **3.2 Орлогын данстай холбоотой**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Түрээсийн төлбөрийн 30% болох 19.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн боловч үүний 7.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй орлого бууруулан тайлагнасан байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-ын 3.9 дах заалтыг зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Мөнгөн гүйлгээний тайлан буруу тайлагнагдах эрсдэлтэй.

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Түрээсийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд бүрэн тусган тайлагнаж байх.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх 2 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06-р сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,146,846.98	163,363,346.18
33	АВЛАГА	26,229,043.57	868,072.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	256,314.67	256,314.67
335	Бусад авлага	25,972,728.90	611,757.93
3351	Байгууллагаас авах авлага	25,675,230.00	608,528.65
3352	Хувь хүмүүсээс авах авлага	297,498.90	3,229.28
35	БАРАА МАТЕРИАЛ	107,917,803.41	162,495,273.58
351	Түүхий эд материал	3,265,850.00	4,043,009.00
35110	Тусгай зориулалттай материал	3,265,850.00	4,043,009.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,623,227.00	4,961,227.00
354	Хангамжийн материал	89,957,792.07	137,591,037.58
35410	Бичиг хэргийн материал	7,049,615.29	7,950,815.29
35420	Аж ахуйн материал	21,568,799.09	55,089,975.59
35430	Сэлбэг хэрэгсэл	477,702.00	477,702.00
35440	Түлш, шатах тослох материал	5,618,370.59	19,695,073.76
35450	Барилгын засварын материал	1,332,223.01	1,332,223.01
35470	Бусад хангамжийн материал	53,911,082.09	53,045,247.93
35600	Мал амьтад	11,070,934.34	15,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,257,442,744.26	52,835,803,461.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,257,442,744.26	52,835,803,461.42
392	Биет хөрөнгө	32,256,606,910.93	52,680,085,128.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,835,223,352.76	47,535,977,901.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	3,444,752,547.10	14,189,505,106.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	470,055,460.00	508,855,460.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	373,221,235.15	386,554,568.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,106,267,800.41	28,022,550,086.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	6,482,852,080.83	8,934,448,750.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	386,746,702.93	397,400,546.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	243,617,031.39	280,097,041.38
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	906,600.00	5,906,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,412,926.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	19,563,036.70	-
393	Биет бус хөрөнгө	835,833.33	378,333.33
39301	Програм хангамж	450,000.00	5,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	442,500.00	5,221,666.67
39303	Бусад биет бус хөрөнгө	5,150,000.00	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	4,321,666.67	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>32,391,589,591.24</b>	<b>52,999,166,807.60</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,019,708.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,019,708.02
413	Өглөг	-	1,019,708.02
4136	Бусад өглөг	-	1,019,708.02
41361	Байгууллагад төлөх өглөг	-	741,758.02
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	277,950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,391,589,591.24	52,998,147,099.58
51	Засгийн газрын хувь оролцоо	32,391,589,591.24	52,998,147,099.58

Замын Үүд сум дэх Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,522,586,754.55	12,677,926,754.55
51101	Өмч: - төрийн	12,522,586,754.55	12,677,926,754.55
512	Хуримтлагдсан үр дүн	18,712,493,401.69	39,557,046,519.23
51210	Өмнөх үеийн үр дүн	18,712,493,401.69	18,712,493,401.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	20,844,553,117.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,156,509,435.00	763,173,825.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>32,391,589,591.24</b>	<b>52,999,166,807.60</b>

## 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,960,156,166.43</b>	<b>29,560,968,546.85</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,878,380,866.43	26,188,971,606.13
120	Нийтлэг татварын бус орлого	11,878,380,866.43	26,188,971,606.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,766,351,903.60	26,133,606,748.47
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,766,351,903.60	26,133,606,748.47
120005	Түрээсийн орлого	41,766,000.00	46,026,000.00
120009	Бусад орлого	70,262,962.83	9,338,857.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,081,775,300.00	3,371,996,940.72
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,081,775,300.00	3,346,991,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,081,775,300.00	3,346,991,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	24,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,005,240.72
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,005,240.72
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,948,757,832.39</b>	<b>8,715,553,269.80</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,948,757,832.39	8,715,553,269.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,948,757,832.39	8,664,030,896.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,321,975,853.06	2,506,370,297.80
210101	Үндсэн цалин	2,110,850,853.06	2,208,852,696.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,125,000.00	62,523,000.00
210104	Урамшуулал	150,000,000.00	234,994,601.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	260,614,511.39	301,143,144.27
210201	Тэтгэврийн даатгал	166,445,145.29	200,930,567.41
210202	Тэтгэмжийн даатгал	22,942,487.28	25,115,907.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,656,091.47	20,511,583.73
210204	Ажилгүйдлийн даатгал	4,688,253.49	4,962,280.86
210205	Эрүүл мэндийн даатгал	46,882,533.86	49,622,804.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,500,589.24	401,673,412.31
210301	Гэрэл, цахилгаан	194,900,360.60	259,878,227.46
210302	Түлш, халаалт	103,606,227.80	116,801,184.85
210303	Цэвэр, бохир ус	24,994,000.84	24,994,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,893,093.72	22,747,183.46
210401	Бичиг хэрэг	11,550,193.72	7,824,061.00
210402	Тээвэр, шатахуун	4,720,300.00	5,809,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,844,200.00	3,391,349.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,672,500.00	1,417,529.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,105,900.00	4,304,443.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,588,369.38	26,208,285.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	281,600.00	3,519,005.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,280,000.00	1,171,900.00
210604	Урсгал засвар	37,026,769.38	21,517,380.00
2107	Томиллолт, зочны зардал	1,308,000.00	2,238,800.00

Замын Үүд сум дэх Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	1,308,000.00	2,238,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,660,113.00	99,490,461.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,984,300.00	71,814,930.50
210803	Даатгалын үйлчилгээ	4,052,950.00	4,051,870.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503,600.00	503,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	638,552.00	26,180.00
210807	Газрын төлбөр	194,400.00	244,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,286,311.00	22,662,881.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,895,217,302.60	5,304,159,312.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,289,900.00	1,020,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	628,000.00	74,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,885,299,402.60	5,303,064,962.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	51,522,372.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	51,522,372.86
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	51,522,372.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,011,398,334.04</b>	<b>20,845,415,277.05</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>337,300,749.01</b>	<b>862,159.51</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	337,300,749.01	862,159.51
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(337,300,749.01)</b>	<b>(862,159.51)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,674,097,585.03</b>	<b>20,844,553,117.54</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,192,492,330.00</b>	<b>3,449,630,607.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,717,030.00	58,139,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,717,030.00	58,139,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,517,030.00	20,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,517,030.00	20,000.00
120005	Түрээсийн орлого	53,910,000.00	58,119,000.00
120009	Бусад орлого	290,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,121,775,300.00	3,391,491,607.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,081,775,300.00	3,346,991,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,081,775,300.00	3,346,991,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	24,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	40,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	20,499,907.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	20,499,907.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,192,492,833.80</b>	<b>3,449,630,607.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,192,492,833.80	3,449,630,607.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,024,162,808.22	3,377,608,327.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,322,868,110.43	2,500,298,286.18
210101	Үндсэн цалин	1,290,631,211.90	1,434,029,186.18
210102	Нэмэгдэл	740,549,798.53	738,602,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,388,500.00	64,388,500.00
210104	Урамшуулал	150,000,000.00	226,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	77,298,600.00	37,278,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,282,943.99	300,626,432.20
210201	Тэтгэврийн даатгал	255,282,943.99	213,081,632.20
210202	Тэтгэмжийн даатгал	-	21,886,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	17,509,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,377,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	43,772,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,978,700.00	390,956,927.46
210301	Гэрэл, цахилгаан	194,900,000.00	274,878,227.46
210302	Түлш, халаалт	91,084,700.00	91,084,700.00
210303	Цэвэр, бохир ус	24,994,000.00	24,994,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,507,903.80	17,804,370.80
210401	Бичиг хэрэг	4,374,003.80	5,199,421.00
210402	Тээвэр, шатахуун	5,666,000.00	6,366,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,844,200.00	3,515,249.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,700.00	1,555,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,068,000.00	1,168,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,511,900.00	56,722,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,800,000.00	10,950,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	1,800,000.00
210604	Урсгал засвар	25,311,900.00	43,972,300.00

Замын Үүд сум дэх Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,308,000.00	2,238,800.00
210702	Дотоод албан томилолт	1,308,000.00	2,238,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,966,650.00	108,886,860.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,243,500.00	89,984,030.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,052,950.00	4,051,870.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503,600.00	503,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,200.00	7,725,460.50
210807	Газрын төлбөр	194,400.00	244,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,247,000.00	6,190,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	738,600.00	74,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	738,600.00	74,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,330,025.58	72,022,279.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,700,000.00	20,499,907.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	20,499,907.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	84,700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,630,025.58	51,522,372.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,630,025.58	51,522,372.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(503.80)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(503.80)	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>503.80</b>	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>D01</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,522,586,754.55</b>	<b>1,156,509,435.00</b>	<b>18,712,493,401.69</b>	<b>32,391,589,591.24</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	155,340,000.00			155,340,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	155,340,000.00	0.00	0.00	155,340,000.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-393,335,609.20		-393,335,609.20
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			20,844,553,117.54	20,844,553,117.54
<b>D09</b>	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>12,677,926,754.55</b>	<b>763,173,825.80</b>	<b>39,557,046,519.23</b>	<b>52,998,147,099.58</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,396,991,700.00	3,353,608,327.14	43,383,372.86	1.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,396,991,700.00	3,353,608,327.14	43,383,372.86	1.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,396,991,700.00	3,353,608,327.14	43,383,372.86	1.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,530,618,800.00	2,500,298,286.18	30,320,513.82	1.20
210101	Үндсэн цалин	1,464,349,700.00	1,434,029,186.18	30,320,513.82	2.07
210102	Нэмэгдэл	738,602,200.00	738,602,200.00	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,388,500.00	64,388,500.00	0.00	0.00
210104	Урамшуулал	226,000,000.00	226,000,000.00	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,278,400.00	37,278,400.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,674,300.00	300,626,432.20	3,047,867.80	1.00
210201	Тэтгэврийн даатгал	216,129,500.00	213,081,632.20	3,047,867.80	1.41
210202	Тэтгэмжийн даатгал	21,886,200.00	21,886,200.00	0.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,509,000.00	17,509,000.00	0.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,377,200.00	4,377,200.00	0.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,772,400.00	43,772,400.00	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	390,978,700.00	390,956,927.46	21,772.54	0.01
210301	Гэрэл, цахилгаан	274,900,000.00	274,878,227.46	21,772.54	0.01
210302	Түлш, халаалт	91,084,700.00	91,084,700.00	0.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	24,994,000.00	24,994,000.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,033,900.00	17,804,370.80	229,529.20	1.27
210401	Бичиг хэрэг	5,200,000.00	5,199,421.00	579.00	0.01
210402	Тээвэр, шатахуун	6,366,000.00	6,366,000.00	0.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,744,200.00	3,515,249.80	228,950.20	6.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,700.00	1,555,700.00	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,000.00	1,168,000.00	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,222,300.00	42,222,300.00	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,950,000.00	10,950,000.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	1,800,000.00	600,000.00	25.00
210604	Урсгал засвар	28,872,300.00	29,472,300.00	-600,000.00	-2.08
2107	Томилолт, зочны зардал	2,308,000.00	2,238,800.00	69,200.00	3.00
210702	Дотоод албан томилолт	2,308,000.00	2,238,800.00	69,200.00	3.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,855,700.00	99,386,860.50	9,468,839.50	8.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,486,600.00	80,484,030.00	9,002,570.00	10.06

Замын Үүд сум дэх Гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	4,053,000.00	4,051,870.00	1,130.00	0.03
210804	Тээврийн хэрэгслийн татвар	967,700.00	503,600.00	464,100.00	47.96
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,725,500.00	7,725,460.50	39.50	0.00
210807	Газрын төлбөр	245,000.00	244,000.00	1,000.00	0.41
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,190,900.00	6,190,900.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	74,350.00	225,650.00	75.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	74,350.00	225,650.00	75.22
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,396,991,700.00</b>	<b>3,405,130,700.00</b>	<b>-8,139,000.00</b>	<b>-0.24</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,346,991,700.00</b>	<b>3,346,991,700.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,346,991,700.00	3,346,991,700.00	0.00	0.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,000,000.00	58,139,000.00	-8,139,000.00	-16.28
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	50,000,000.00	58,119,000.00	-8,119,000.00	-16.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,000.00	-20,000.00	0.00